

Орхоны хөндийн БЦГ-ын

Хамгаалалтын захиргааны 2016 оны 05 сарын мэдээ

2016.05.23

Байгалийн нөөцийн менежмент

Өвөрхангай аймгийн Хархорин сумын ЗДТГ, Хархорин музей, Дэлхийн өв-Орхоны хөндийн СДГазартай хамтран Хархорин суманд байх түүх соёлын өвийн бүртгэл тооллогын ажлыг хийж гүйцэтгэлээ.



Тооллогоор тусгай хамгаалалтай газар нутагт байх дурсгалуудыг 20 иргэнд гурвалсан гэрээгээр хариуцуулан өглөө.

БОНХАЖЯ-ны ТНБДаргын 2016 оны 04-р сарын 28-ны өдрийн А/52- р тушаалаар томилогдсон Орхоны хөндийн БЦГ-ын хилийн заагт өөрчлөлт оруулах үндэслэлийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хамгаалалтын захиргааны дарга Г.Эрдэнэбилэг, мэргэжилтэн Ч.Суурьтогтох, Д.Эрдэнэчимэг нар оролцож 5-р сарын 10 өдөр сум, аймаг орон нутгийн төлөөллүүдтэй газар дээр нь очиж судалгаа хийж ажиллаа.



Ажлын хэсэг орон нутгаас санал болгосон чөлөөлөхийг хүссэн газар нутаг, нутгийн иргэдийн саналыг авч хэлэлцүүлэгтээ тусган чөлөөлөгдөх газрын солбилцолыг тогтоож тойм зургийг гарган УТХГН-аас гаргахаар санал болгосон Улаан ам багийн төвийг чөлөөлөхгүйгээр экологийн магадлан шинжилгээ хийж ерөнхий төлөвлөгөө боловсруулан түүний дагуу хөгжүүлэхээр тогтоов.

УТХГ-ын аялал жуулчлалын бүсээс чөлөөлөгдсөн газрын хэмжээнээс бууруулаагүй өөр газрыг аялал жуулчлалын бүс болгох саналыг холбогдох газарт хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Могойтын аманд 2,5 га талбайд 3500 ширхэг шинэсний 3-н настай тарьцаар тус сумын Өвт хайрхан, Сүүн далай трейвэл ХХК, Харуул

магнай, Могойт хайрхан, Цэгээн нуур нөхөрлөл, Хужирт сумын Өгөөмөр шунхлай ХХК хамтран ойжуулалт хийж хамгаалалтын хашааг ойр орчимд байгаа унангаар хийж Могойт хайрхан нөхөрлөлд хамгаалалтын ажлыг хариуцуулан өглөө.



Бүх нийтээр мод тарих өдөр Хархорин сумын цэцэрлэгт хүрээлэн болон ОХБЦГ-ын хамгаалалтын захиргааны хашаан дахь мод, бутанд арчилгаа хийж усаллаа.



Бат-өлзий сумын орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг бүс нутгийн ард иргэдтэй уулзаж судалгаа хийлээ. Энэ судалгаагаар ТХГН-ын орчны бүсийн тухай ойлголт мэдээлэл өгч байгаль экологи, уур амьсгал 10 жилийн давтамжаар хэрхэн өөрчлөгдөж байгаа болон, байгаль хамгаалахад иргэдийн оролцоо хэр байна, цаашид анхаарах гол асуудлууд, ард иргэдийн амжиргааны эх үүсвэр болон нэмэгдүүлэх боломжийн талаар анхан шатны судалгаа мэдээлэл цуглууллаа. Судалгааг ОБМТ боловсруулах ажлын хэсгийн 2 баг гарч нийт 500 гаруй км зам туулж 100 аад өрх, 193 иргэнтэй уулзалт хийсэн.



Ард иргэдээс авсан судалгааг нэгтгэх, гарсан дүнг боловсруулах ажлыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нар гүйцэтгэж, судалгаанаас гарсан үр дүнг танилцуулах дүнгийн хурлыг зарлан хуралдууллаа. Судалгаанд оролцсон иргэдийн 56% нь эрэгтэй, 44 %

нь эмэгтэйчүүд хамрагдаж, орчны бүс нутагт хамгаалах үнэт зүйлсийг жагсаалтаар нь гаргаж иргэдийн байгаль орчиндоо оруулж байгаа хувь нэмэр, амжиргааны боломжуудын талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулж, ОБМТөлөвлөгөөг боловсруулах, баг, сумын ИТХ-д танилцуулах цаг хугацааны товыг хэлэлцэн тохирлоо.

Мэдээлэл, сургалт, аялал жуулчлал

БОНХАЖЯамнаас зохион байгуулсан “Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь” сургалт Хархорин суманд боллоо. Энэхүү сургалтанд Аялал жуулчлалын бодлого, Үндэсний хөтөлбөр, Орон нутгийн хөтөчийн соёл, Ногоон хөгжил-Эко аялал жуулчлалын талаар БОНХАЖЯ-ны БОАЖ-ын Бодлого зохицуулалтын газрын дарга мэргэжилтнүүд, Хөтөч тайлбарлагчдын холбооны албаны дарга мэдээлэл өгч, ТХГН-ын Аялал жуулчлал, Хүрхрээ бүсийн "Хүрмэн чулуу нөхөрлөл" илтгэлүүдийг Хамгаалалтын захиргааны дарга Г. Эрдэнэбилэг, нөхөрлөлийн ахлагч Мягмарсүрэн нар тавьсан. Мөн 21 аймгаас ирсэн БОАЖГ-ын аялал жуулчлалын мэргэжилтнүүд оролцож өөрсдийн аймгийн аялал жуулчлалын онцлог, НИТАЖ-ыг хөгжүүлэхэд санаа авах онцлог ажлуудынхаа талаар мэдээлэл өгсөн.



НИТАЖ-ыг хөгжүүлэх нь сургалтанд БОНХАЖСайд Н. Батцэрэг ирж оролцон аялал жуулчлалын талаар яамнаас баримталж буй бодлого чиглэлийн талаар мэдээлэл хийлээ.



Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан “Ойн зохистой ашиглалтанд ойн нөхөрлөл, ойн мэргэжилийн байгууллага, ойн ангийн оролцоо” сэдэвт зөвлөгөөнд хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэчимэг, байгаль хамгаалагч, байцаагч Д.Дүгэрдорж нар оролцлоо.

Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргаанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. Байгаль орчны сэдэвт шилдэг илтгэл шалгаруулах уралдааны удирдамж гарган харьяа 6 сумдын ЕБСургуулиудын сурагчдад хүргүүлээд байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явагдах гэж байгаатай холбогдуулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хяналт шалгалт

Хархорин сумын Орхон багийн иргэн А.Бямбасамбуу ТХГН-аас 1,7 м³ мод бэлтгэсэн зөрчил илэрч, Сум дундын ойн ангиас 183600 төгрөгийн экологи эдийн засгийн үнэлгээ гаргасанд 550800 төгрөгний нөхөн төлбөр тогтоож, 960000 төгрөгний торгууль ногдуулж захиргааны арга хэмжээ авч бэлтгэсэн модыг хурааж Хархорин сумын засаг даргын дэргэдэх захиргааны зөвлөлд хүлээлгэн өглөө.

Өвөрхангай аймгийн Хужирт сумын Уньт, Их сайрт, Бага сайрт гэх газар нутагт амьдарч байгаа 22 өрх, Архангай аймгийн Орхон багийн 11 өрх, Бат-Өлзий сумын Онгоцот, Зуухан, Сант, Сүвээг 25 өрх, Мухдаг, Дөрвөлжин Баруун эх, Баруун цөөм, нурам, Хүрмэн нутаглах 25 өрх, нийт 83 өрхийн, 251 иргэнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж тараан гэрээ байгуулан ТХГН, Ойн тухай, Зөрчлийн тухай, Ан амьтаны хуулиар ухуулга сурталчилгаа хийж хамтран ажиллах гэрээ байгуулж морин эргүүл хийж ажиллаа.



2016 оны 5-р сарын 15-нд Архангай аймгийн Орхон багийн засаг дарга Гансүх, Өвөрхангай аймгийн Хужирт сумын Бэрх багийн засаг дарга Галиндив нартай Өндөр сант хайрханы тахилгын үйл ажиллагааг нутгийн 150 гаруй иргэдтэй хамтран зохион байгууллаа. Тахилгын үеэр нутгийн иргэдэд Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болон хог хаягдлын тухай хуулиар ухуулга сурталчилгаа хийж ойр орчмын хогийг цэвэрлэн ажиллаа.

Мэдээллийн сан

Орчин зүйн ажиглалт явуутын судалгааг тогтмол хийж байна. Бат-Өлзий сумын Улаан мод гэх газар Бор гөрөөс 3, Ташууд Тарвага 18, Чоно 1, Архангай аймгийн Хотонт сумын Давааны аманд Тарвага 13, Дунд аманд Тарвага 12, Оторын мухарт Тарвага 15 орчим, Хярс

1, Бор туулай 1, Хужирт сумын Орхон голд Хун 12, Ангир 6, Бор галуу 16, Хашаатын Цайдам багт Тогоруу 4, Зээр 25 ажиглагдсан мэдээг байгаль хамгаалагчдаас авч мэдээллийн санд нэгтгэлээ.

Мөн Цайдам багийн ТХГН болон орчны бүсэд байрлах худгийг тоолж кординатыг тогтоон фотозургаар баримтжуулж ажиллаа.

Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн Ч.Суурьтогтох.